

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/06/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүү-нийцлийн газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 51-260512 Цахим хаяг: enkhbaatare@ audit.gov.mn Ахлах аудитор: П.Батцэцэг Утас: 51-261628 Цахим хаяг: battsetsegp@audit.gov.mn Аудитор: Г.Сампилмаа Утас: 51-261628 Цахим хаяг: sampilmaag@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Сангийн гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	11
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	11
3.6 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	16
5.1.1 Албан шаардлага	16
5.1.2 Зөвлөмж.....	17
5.2 Жижиг, дунд үйлдвэрийн газар.....	18
5.2.1 Төлбөрийн акт	18
5.2.2 Албан шаардлага	18
5.2.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЖДҮГ	Жижиг, дунд үйлдвэрийн газар
ХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ДАРГА Я.ЭРДЭНЭСАЙХАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 06/805
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тайлант онд сангаас олгосон шууд зээлийн 202 зээлдэгчийн 30,439.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 255.5 сая төгрөгийг гадаад албан томилолтын зардалд зарцуулсан;
- Монгол банкны зээлийн мэдээллийн санд 1,312.7 сая төгрөгийн зээлийн ангиллыг зөрүүлсэн;
- Тайлант онд олгосон зээлээс 4,901.5 сая төгрөгийн зээл нь чанаргүй зээлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.3, 41.2.7, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох журмын 2 дугаар зүйлийн 2.1, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “үнэн зөв байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь тайлант онд хөнгөлөлттэй зээлийн үйл ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлж, нийт 1210 аж ахуйн нэгжээс 174,087.5 сая төгрөгийн зээлийн хүсэлтийг хүлээн авч, сонгон шалгаруулалтын үр дүнд 324 төсөлд 47,820.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хэрэгжилт тодорхой түвшинд хүрсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Шууд зээлийн авлагын үлдэгдэл 186,030.9 сая төгрөгөөс тайлант хугацаанд 38,194.6 сая төгрөгийн авлагыг барагдуулж, 47,875.7 сая төгрөгийн зээлийг олгож тайлант оны эцэст шууд зээлийн 40.5 хувь буюу 79,282.9 сая төгрөгийн 273 зээлдэгчээс авах авлага "муу зээл"-ийн ангилалд бүртгэлтэй байна.

Засгийн газрын тусгай сангийн хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх заалтын дагуу 11 аймагтай гэрээ байгуулан хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн санхүүжилтэд 6,635.8 сая төгрөгийг бүрдүүлсэн байна. Уг санхүүжилтийг тайлант оны батлагдсан төлөвлөгөөнд тусгаагүй, үндсэн дансаар авч зарцуулсан нь орлогын гүйцэтгэлийн өсөлтөд нөлөөлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нэмэлт горим сорил гүйцэтгэх үүрэг хүлээдэг.

Дотоод, гадаадын нийт 35 арга хэмжээг зохион байгуулж, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжин 4,800.0 сая төгрөгийн борлуулалт хийлгэсэн. Аймаг, нийслэлийн хэмжээнд салбарын чадавх, хүртээмжийг үнэлсэн суурь болон бодлогын судалгааг хийж, шийдвэр гаргалтад ашиглах санал боловсруулан төрийн байгууллагуудтай хамтран нийлүүлэлтийн сүлжээнд жижиг, дунд үйлдвэрлэгчдийг холбох гэрээ байгуулж, зах зээлийг тэлэх бодит дэмжлэг үзүүлсэн байна.

Мөн бизнес инкубатор төвүүдэд нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлж, 2000 гаруй аж ахуйн нэгжийг чадавхжуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	274,652,249,238.83	279,899,282,790.59
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,287,745,734.48	15,976,620,495.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	15,287,745,734.48	15,976,620,495.00
31210	Төгрөг	15,287,745,734.48	15,976,620,495.00
31211	Төрийн сангийн харилцах	15,287,745,734.48	15,976,620,495.00
33	АВЛАГА	237,374,198,387.94	241,591,425,143.18
33500	Бусад авлага	528,090,311.46	516,151,843.27
33510	Байгууллагаас авах авлага	302,608,178.13	303,305,709.94
33520	Хувь хүмүүсээс авах авлага	225,482,133.33	212,846,133.33
33600	Зээлийн авлага	236,846,108,076.48	241,075,273,299.91
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	236,846,108,076.48	241,075,273,299.91
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	236,846,108,076.48	241,075,273,299.91
35	БАРАА МАТЕРИАЛ	78,500,000.00	62,800,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	78,500,000.00	62,800,000.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	21,911,805,116.41	22,268,437,152.41
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ +Бусад	21,911,805,116.41	22,268,437,152.41
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	274,652,249,238.83	279,899,282,790.59
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	22,582,049,888.05	28,719,291,527.94
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	470,720,388.05	655,932,027.94
41300	Өглөг	244,694,666.00	278,951,879.47
41350	Зээлийн хүүгийн өглөг	-	34,257,213.47
41360	Бусад өглөг	244,694,666.00	244,694,666.00
41361	Байгууллагад төлөх өглөг	244,694,666.00	244,694,666.00
41400	Урьдчилж орсон орлого	226,025,722.05	376,980,148.47
41440	Бусад урьдчилж орсон орлого	226,025,722.05	376,980,148.47
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,111,329,500.00	28,063,359,500.00
42200	Урт хугацаат зээл	22,111,329,500.00	28,063,359,500.00
42210	Төгрөг	22,111,329,500.00	28,063,359,500.00
42217	Санхүүгийн бусад байгууллага	22,111,329,500.00	28,063,359,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	252,070,199,350.78	251,179,991,262.65
51	Засгийн газрын хувь оролцоо	252,070,199,350.78	251,179,991,262.65
51200	Хуримтлагдсан үр дүн	252,070,199,350.78	251,179,991,262.65
51210	Өмнөх үеийн үр дүн	250,566,975,876.76	249,057,840,574.28
51220	Тайлант үеийн үр дүн	1,503,223,474.02	2,122,150,688.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	274,652,249,238.83	279,899,282,790.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,235,690,249.13	4,003,725,924.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,772,718,249.13	4,003,725,924.70
120	Нийтлэг татварын бус орлого	2,772,718,249.13	4,003,725,924.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,772,718,249.13	4,003,725,924.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,200,592.82	4,003,725,924.70
1200046	Зээлийн хүүгийн орлого	2,714,517,656.31	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,462,972,000.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,462,972,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,462,972,000.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,536,215,800.00	1,559,219,101.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,536,215,800.00	1,559,219,101.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,536,215,800.00	1,559,219,101.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,536,215,800.00	1,559,219,101.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,536,215,800.00	1,559,219,101.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,699,474,449.13	2,444,506,823.70
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	196,250,975.11	322,356,135.33
230001	Эргэж төлөгдөх зээл	196,250,975.11	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	322,356,135.33
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(196,250,975.11)	(322,356,135.33)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,503,223,474.02	2,122,150,688.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	54,774,641,685.57	48,628,623,714.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,311,669,685.57	48,628,623,714.70
120	Нийтлэг татварын бус орлого	53,311,669,685.57	48,628,623,714.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,311,669,685.57	48,628,623,714.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	53,311,669,685.57	41,992,793,714.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,462,972,000	6,635,830.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,462,972,000	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,462,972,000	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	54,774,641,685.57	48,628,623,714.70
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	39,486,895,951.09	47,939,748,954.00
230001	Эргэж төлөгдөх зээл	39,486,895,951.09	47,939,748,954.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(39,486,895,951.09)	(47,939,748,954.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	15,287,745,734.48	688,874,760.70
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	15,287,745,734.48
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,287,745,734.48	15,976,620,495.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			254,869,653,210.85	254,869,653,210.85
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(4,302,677,334.09)	(4,302,677,334.09)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			250,566,975,876.76	250,566,975,876.76
Тайлант үеийн үр дүн			1,503,223,474.02	1,503,223,474.02
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			252,070,199,350.78	252,070,199,350.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(3,012,358,776.50)	(3,012,358,776.50)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			249,057,840,574.28	249,057,840,574.28
Тайлант үеийн үр дүн			2,122,150,688.37	2,122,150,688.37
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл			251,179,991,262.65	251,179,991,262.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛС ЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	45,000,000,000.00	48,628,623,714.70	(3,628,623,714.70)	108.1
12	Татварын бус орлого	45,000,000,000.00	48,628,623,714.70	(3,628,623,714.70)	108.1
120	Нийтлэг татварын бус орлого	45,000,000,000.00	48,628,623,714.70	(3,628,623,714.70)	108.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого / үндсэн/	45,000,000,000.00	48,628,623,714.70	(3,628,623,714.70)	108.1
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого / туслах/	-	6,635,830,000.00	(6,635,830,000.00)	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	44,831,925,000.00	47,197,246,454.00	(2,365,321,454.00)	105.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	44,831,925,000.00	47,197,246,454.00	(2,365,321,454.00)	105.3
230001	Эргэж төлөгдөх зээл	44,831,925,000.00	47,197,246,454.00	(2,365,321,454.00)	105.3
8	ТЭНЦВЭРЖҮҮЛС ЭН НИЙТ ТЭНЦЭЛ	168,075,000.00	1,431,377,260.70	(1,263,302,260.70)	851.6
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(168,075,000.00)	(1,431,377,260.70)	1,263,302,260.70	851.6
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(168,075,000.00)	(1,431,377,260.70)	1,263,302,260.70	851.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	15,287,745,734.48		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	16,719,122,995.18		
62	АЖИЛЛАГСАДЫ Н ТОО	39	39	-	100.0
620001	Удирдах ажилтан	5	5	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	34	34	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, түүний үйл ажиллагаа

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршооны салбарыг эрчимтэй хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, үндэсний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах, хөнгөлөлттэй зээл, татаас олгох, улмаар нийгэм, эдийн засагт жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарын эзлэх байр суурийг бэхжүүлэх, тэдгээрийн хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлж, төрийн дэмжлэг үзүүлэх, тэдний эрх ашигт нийцсэн бизнесийн таатай орчныг бүрдүүлэх эрхэм зорилготой Засгийн газрын тусгай сан юм.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох;
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид бүтээгдэхүүнээ экспортод гаргасан бол зээлийн хүүгийн татаас олгох;
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд бизнес, инкубацийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, сургалт, давтан сургалтад хамруулах;
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
- Шаардлагатай тохиолдолд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан жижиг, дунд үйлдвэрийг дэмжихэд чиглэсэн тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үндсэн болон өр барагдуулахтай холбогдсон үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэх.

3.2 Сангийн гадаад, дотоод орчин

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтыг бүтцийн өөрчлөлт, хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг баталсан байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, инновацыг дэмжих, шинээр бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болох, нэмэгдүүлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд тус сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх арилжааны банкныг сонгох, эргэн төлүүлэх, хяналт мониторинг хийх үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Тайлант онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль, тогтоомж бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;

Сангийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Жижиг, дунд үйлдвэрийн газрын аудит, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн нь тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,247.0 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15,287,745.7	15,976,620.5	688,874.8
Авлага	237,374,198.4	241,591,425.1	4,217,226.7
Бараа материал	78,500.0	62,800.0	(15,700.0)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	21,911,805.1	22,268,437.2	356,632.1
Нийт хөрөнгө	274,652,249.2	279,899,282.8	5,247,033.6
Богино хугацаат өр төлбөр	470,720.4	655,932.0	185,211.6
Урт хугацаат өр төлбөр	22,111,329.5	28,063,359.5	5,952,030.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	252,070,199.4	251,179,991.3	(890,208.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	274,652,249.2	279,899,282.8	5,247,033.6

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 15,976.6 сая төгрөг болж 688.9 сая төгрөгөөр өссөн нь зээлийн эргэн төлөлтөөс орсон орлогын зарцуулаагүйтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 241,591.4 сая төгрөг болж 4,217.2 сая төгрөгөөр өссөн нь ХХААХҮС-ын 2025 оны А/37, А/85, А/86, А/89, А/158, А/159, А/355, А/358, А/356, А/357, А/359, А/360, А/361, А/362 дугаар тушаалуудаар жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох ерөнхий нөхцөлийг баталж, тайлант онд 324 аж ахуйн нэгж, байгууллагад 47,820.5 сая төгрөгийн 5 жилийн хугацаатай, жилийн 5 хувийн хүүтэй хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгосон, нийт шууд зээлийн 40.5 хувь буюу 79,282.9 сая төгрөгийг муу зээл, 7.4 хувь буюу 14,515.3 сая төгрөгийг хугацаа хэтэрсэн, 46.2 хувь буюу 90,338.3 сая төгрөгийг хэвийн, 3.2 хувь буюу 6,234.0 сая төгрөгийг хэвийн бус, 2.7 хувь буюу 5,371.7 сая төгрөгийг эргэлзээтэй зээлийн ангилалд бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 62.8 сая төгрөг болж 15.7 сая төгрөгөөр буурсан нь шууд зээлийн эргэн төлөлтөд хураан авч бэлэн бүтээгдэхүүн дансанд бүртгэлтэй байсан 15.7 сая төгрөгийн арьс, ширний тоног төхөөрөмжийг борлуулсантай холбоотой байна.

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 22,268.4 сая төгрөг болж 356.6 сая төгрөгөөр өссөн нь 456.6 сая төгрөгийн Дүнжингаравын овоон энгэр барилга, газрыг бүртгэж, дуудлага худалдаагаар 56.0 сая төгрөгийн агуулах, 44.0 сая төгрөгийн барилга байгууламжийг борлуулж данснаас хассанаас шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 655.9 сая төгрөг болж, 185.2 сая төгрөгөөр өсөхөд Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн нэмэлт санхүүжилтийн дамжуулан зээлийн хүүгийн өглөгийн 93.0 сая төгрөгийг бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 28,063.4 сая төгрөг болж, 5,952.0 сая төгрөгөөр өссөн нь Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, хөнгөлөлттэй зээл олгохоор Өмнөговь аймгийн ЗДТГ-аас 3,285.8 сая төгрөг, Өвөрхангай аймгийн ЗДТГ-аас 500.0 сая төгрөг, Сүхбаатар аймгийн ЗДТГ-аас 300.0 сая төгрөг, Ховд аймгийн ЗДТГ-аас 300.0 сая төгрөг, Орхон аймгийн ЗДТГ-аас 300.0 сая төгрөг, Завхан аймгийн ЗДТГ-аас 500.0 сая төгрөг, Дундговь аймгийн ЗДТГ-аас 400.0 сая төгрөг, Дорнод аймгийн ЗДТГ-аас 500.0 сая төгрөг, Говь-Сүмбэр аймгийн ЗДТГ-аас 300.0 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн ЗДТГ-аас 100.0 сая төгрөг, Архангай аймгийн ЗДТГ-аас 150.0 сая төгрөг нийт 6,635.8 сая төгрөгийг бүрдүүлж, Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөлд 683.8 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 251,180.0 сая төгрөг болж, 890.2 сая төгрөгөөр буурсан нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр санхүүгийн тайланд шууд зээлийн авлагын 3,012.4 сая төгрөгийг залруулсан, тайлант үеийн үр дүн 2,122.2 сая төгрөгтэй гарсан зэргээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 50,000.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 25,000.0 сая төгрөг, төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх 162.0 сая төгрөгийг бүрдүүлж, дамжуулан зээлийн эргэн төлөлтөд 162.0 сая төгрөг, эргэж төлөгдөх зээлээс 75,000.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвөөс санхүүжих 50,000.0 сая төгрөгийг хасаж, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгох санхүүжилтийг 45,000.0 сая төгрөг, төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх 168.1 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Тайлант хугацаанд тодотгол хийгдээгүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга үйл ажиллагааны орлогоос 47,992.8 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 6,635.8 сая төгрөг нийт 48,628.6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуй нэгж байгууллагуудад эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр 45,000.0 сая төгрөгийн зээл олгохоор баталсан байна.

Гүйцэтгэлээр жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуй нэгж байгууллагуудад эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр 47,197.2 сая төгрөгийг зарцуулж, улсын төсвийн харилцах дансанд 15,976.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт (хувь)
	Код	Нэр				

1	72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	45,000,000.0	48,628,623.7	(3,628,623.7)	108.1
1.1	81404	Дамжуулан зээлдүүлсэн зээл	168,075.0	1,431,377.2	(1,263,302.2)	851.6
1.2	81405	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	44,831,925.0	47,197,246.5	(2,365,321.5)	105.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

Жижиг, дунд үйлдвэрийн газрын даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө” баталж, А/125 дугаар тушаалаар тодотгож баталсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд үндсэн үйл ажиллагааны орлогоос 14 төсөл арга хэмжээг 289.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусгаснаас 259.0 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээг шууд худалдан авахаар, 30.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 26.9 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 248.7 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээг шууд худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн сангийн үйл ажиллагааг сайжруулах үндсэн хөрөнгийн данс, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Батцэцэг, аудитор Г.Сампилмаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/278/а дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,536.2 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож 25.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь сургалт семинарыг цахимаар зохион байгуулах, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйлс худалдан аваагүй зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн асуудлаар нийт 27,906.6 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлж, түүнд 27,906.6 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь Шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12,235.5 сая төгрөгийн 440 гүйлгээг, 15,369.7 сая төгрөгийн зарлагын 147 гүйлгээг тус тус байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Жижиг, дунд үйлдвэрийн газар нь Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 57.0 сая төгрөгийн 25 гүйлгээ, 244.4 сая төгрөгийн зарлагын 24 гүйлгээг тус тус байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, илрүүлсэн 2,250.1 сая төгрөгийн зөрчлийг асуудлын бүртгэлээр танилцуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 30,835.5 сая төгрөгийн 4 албан шаардлага, 1,832.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгснийг 62.5 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	30,835,478.0	3	11,393,457.8	75.0
Зөвлөмж	4	1,832,408.2	2	-	50.0
Дүн	8	32,667,886.2	5	11,393,457.8	62.5

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Шууд зээлийн 134 зээлдэгчийн 19,442.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Зээлийн эргэн төлөлтөд хураан авсан борлуулах зорилготой 21,911.8 сая төгрөгийн хөрөнгийг эргэлтэд оруулаагүй ашиглалтын нэмэлт зардал гарсан;
- Шилэн дансны цахим хуудсанд 152 мэдээлэл оруулахаас 5 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт оруулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 1,762.4 сая төгрөгийн 38 орлогын, 70.0 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Жижиг дунд үйлдвэрийн газрын даргын 2024 оны А/15 болон А/232 дугаар тушаалаар фискус зээлийн программ болон санхүүгийн бүртгэлийн программын хооронд зөрүүтэй бүртгэгдсэн асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36,927.1 сая төгрөгийн 12 зөрчил¹ илэрснээс, 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 36,843.4 сая төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлж, 82.1 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 36,927.1 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 36,901.7 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

Аудитаар нийт 36,716.5 сая төгрөгийн 7 зөрчил илэрсэнд 36,653.7 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 62.8 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1.1 Албан шаардлага

1. Илрүүлэлт: Сангаас тайлант оны жилийн эцсийн байдлаар 324 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд 47,820.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Үүнээс 26 зээлдэгчийн 4,118.3 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 4 зээлдэгчийн 783.2 сая төгрөгийн зээл хэвийн бус төлөвтэй бөгөөд тайлант онд олгосон нийт зээлийн 10.2 хувь нь сангийн чанаргүй зээлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зориулалттай байна”, Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 15 дугаар зүйлийн 15.1-д “Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрч, хэвийн бус зээлийн үлдэгдэл нэмэгдэж, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Илрүүлэлт: Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтөд хураан авсан 22,368.4 сая төгрөгийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгүүдийг эргэлтэд оруулахаар дуудлага худалдаа зохион байгуулсан боловч сонирхогч этгээд оролцоогүй байна. Тус хөрөнгүүдийн ашиглалт, хадгалалт, хамгаалалттай холбоотой зардал нэмэгдэж, хөрөнгийн чанар байдал алдагдан, сангийн түргэн хөрвөх чадварт сөргөөр нөлөөлж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.*”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Жижиг, дунд, үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т “*жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний хууль тогтоомж, төрийн бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах*”, ЗГ-ын 113 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2 дугаар сарын 2.1-т “*Зээлийн эх үүсвэр нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан эх үүсвэрээс бүрдэнэ*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, эргэн төлөлтөд хураан авсан хөрөнгийг эргэлтэд оруулаагүй, урсгал зардал гаргаж байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Илрүүлэлт: Тус сан нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хуульд заасан хугацаанаас 30 хоног хоцроож Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаа хоцроож ирүүлдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. Илрүүлэлт: Монгол банкны зээлийн мэдээллийн санд 1300 зээлдэгчийн 193,597.2 сая төгрөгийн бодит зээлийн үлдэгдэл бүртгэлтэй байгаагаас гэрээний хугацаа дууссан 21 зээлдэгчийн 1,312.7 сая төгрөгийн зээлийн ангиллыг зөрүүтэй нийлүүлсэн байна. Үүнд: 6 зээлдэгчийн 669.2 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ангилалд, 6 зээлдэгчийн 253.1 сая төгрөгийн зээл хэвийн ангилалд, 4 зээлдэгчийн 67.4 сая төгрөгийн зээл хэвийн бус ангилалд, 5 зээлдэгчийн 323.0 сая төгрөгийн зээл эргэлзээтэй ангилалд байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Зээлийн мэдээллийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "зээлийн мэдээлэл үнэн зөв, бодитой, тодорхой, бүрэн гүйцэд, ойлгомжтой байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол банкны зээлийн мэдээллийн санд зээлийн ангиллыг зөрүүтэй нийлүүлсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5. Илрүүлэлт: Шууд зээлийн 202 зээлдэгчийн 30,439.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 113 дугаар тогтоолоор баталсан "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох журам"-ын 16 дугаар зүйлийн 16.1.1-т "зээл авсан иргэн, аж ахуй нэгжийн төслийн үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн талаарх тайланг зээлдэгчээс улирал бүр гаргуулан авах"; гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант оны эцэст авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сангийн бэлэн бүтээгдэхүүн дансанд "санхүүгийн түрээс"-ээр худалдах зорилготой 32 ширхэг 62.8 сая төгрөгийн өртөг бүхий 1-ээс дээш жилийн насжилттай тоног төхөөрөмжүүдийг эргэлтэд оруулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бэлэн бүтээгдэхүүний дансанд удаан хугацаанд эргэлтэд ороогүй тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээсээр худалдах, ашиглалтад оруулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх.

2. Зээлийн мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Зээлийн мэдээллийн санд 223 зээлдэгчийн зээлийн гэрээнд заасан зориулалтыг буруу болон зөрүүтэй бүртгэсэн байна.

Энэ нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6.зээлийн мэдээллийг тогтмол баяжуулан, шинэчилж байх; гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зээлийн гэрээнд заасан зориулалтыг зээлийн мэдээллийн санд үнэн зөв бүртгэх, буруу болон зөрүүтэй бүртгэсэн мэдээллийг залруулж мэдээллийн сангийн бүртгэлийг шинэчлэх.

5.2 Жижиг, дунд үйлдвэрийн газар

Аудитаар нийт 210.6 сая төгрөгийн 5 зөрчил илэрснээс, 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 189.7 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 19.3 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.2.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Гадаад томилолтын зардлыг олгохдоо хот доторх унааны зардлыг 1.6 сая төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Сангийн сайдын 2011 оны 188 дугаар "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" Хоёр. Гадаад томилолтоор явагчдад хот доторх унааны зардлын хэмжээг тухайн хотод байх хугацааг хоногт 10 ам.доллараар тооцож олгосугай" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон 1.6 сая төгрөгийг буцаан төлүүлж улсын төсөвт төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2.2 Албан шаардлага

1. **Илрүүлэлт:** Тайлант онд үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Тоёота Ланд Круйзер-200 маркын 12-77 УНА улсын дугаар бүхий авто тээврийн хэрэгслийг даатгалд хамруулж, даатгалын төлбөрт 1.4 сая төгрөгийн зардал гарсан боловч байгалийн гамшигт үзэгдлийн улмаас гэмтсэн машины засварын зардалд 5.1 сая төгрөгийг даатгалын компаниас нэхэмжлэлгүй төсвөөс зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Даатгалын байгууллагаас төлбөрийг нөхөн гаргуулах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.

2. Илрүүлэлт: Илүү цагаар ажилласан ажилтны бүртгэлийн хуудсыг баталгаажуулаагүй нэр бүхий 36 ажилтанд 1052 цаг илүү ажилласнаар тооцож 23.2 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү цагаар ажилласан ажилтны бүртгэлийн хуудсыг баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Илрүүлэлт: Бельгийн Брюссель, Холбооны Бүгд Герман улсын Фрайбург хотуудад Дэлхийн Монголчуудын наадмын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зардалд 161,376,803.00 /нэг зуун жаран нэгэн сая гурван зуун далан зургаан мянга найман зуун гурван/ төгрөгийг шилжүүлсэн боловч гүйцэтгэсэн ажлын тайлан байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэлгүй, гүйцэтгэсэн ажлын тайланг хавсаргаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Зөвлөмж

Илрүүлэлт: ЖДҮГ нь Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэлийн дагуу Дархан-Уул аймагт шилжин ажиллах шийдвэр гарсан боловч зарим албан хаагчид Улаанбаатар хотод ажиллаж, байр ашиглалтын зардалд 19.3 сая төгрөгийг давхардуулан зарцуулж байна.

Энэ нь ЗГ-ын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 32 дугаар хуралдааны тэмдэглэлийн 1-д "Төвийн бүсийг "Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс" болгон хөгжүүлэхтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон түүний харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх ажлыг төлөвлөн, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, шилжүүлэн ажиллуулах асуудлыг бүрэн шийдвэрлэх, төсвийг хэмнэлттэй зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Үүнээс											
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	Сангаас тайлант оны жилийн эцсийн байдлаар 324 жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд 47,820.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Үүнээс: 26 зээлдэгчийн 4,118.3 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 4 зээлдэгчийн 783.2 сая төгрөгийн зээл хэвийн бус төлөвтэй байгаа бөгөөд тайлант онд нийт олгосон зээлийн 10.2 хувь нь чанаргүй зээлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.	1	4,901,500.0			1	4,901,500.0						
	Сангийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтөд хураан авсан бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 22,368.4 сая төгрөгийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгүүдийг эргэлтэд оруулахаар дуудлага худалдаа зохион байгуулсан боловч сонирхогч этгээд оролцоогүй байна. Тус хөрөнгүүдтэй холбоотойгоор	1	-			1	-						

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<p>ашиглалт, хадгалалт, хамгаалалтын урсгал зардал гарч, хөрөнгийн чанар байлдалд болон сангийн түргэн хөрвөх чадваруудад сөргөөр нөлөөлж, хадгалалт, хамгаалалт алдагдаж байна. Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.</p>												
<p>ЖДҮХСангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан хугацаанаас 30 хоногийн хугацаа хоцроож ирүүлсэн байна.</p>	1		-			1		-				
<p>Монгол банкны зээлийн мэдээллийн санд 1300 зээлдэгчийн 193,597.2 сая төгрөгийн бодит зээлийн үлдэгдэл бүртгэлтэй байгаагаас гэрээний хугацаа дууссан боловч 21 зээлдэгчийн 1,312.7 сая төгрөгийн зээлийг ангиллыг зөрүүтэй нийлүүлсэн байна. Үүнд: 6 зээлдэгчийн 669.2 сая төгрөгийн зээлийг хугацаа хэтэрсэн ангилалд; 6 зээлдэгчийн 253.1 сая төгрөгийн зээлийг хэвийн ангилалд; 4 зээлдэгчийн 67.4 сая төгрөгийн зээлийг хэвийн бус ангилалд; 5 зээлдэгчийн 323.0 сая төгрөгийн зээлийг эргэлзээтэй ангилалд тус тус буруу ангилж, зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн байна.</p>	1	1,312,690.6				1	1,312,690.6					

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Шууд зээлийн 202 зээлдэгчийн 30,439,514,342.00 /гучин тэрбум дөрвөн зуун гучин есөн сая таван зуун арван дөрвөн мянга гурван зуун дөчин хоёр/ төгрөгийн авлагын үлдэгдэлийг жилийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	30,439,514.3			1	30,439,514.3						
	Сангийн бэлэн бүтээгдэхүүн дансанд "санхүүгийн түрээс"-ээр худалдах зорилготой 32 ширхэг 62.8 сая төгрөгийн өртөг бүхий 1-ээс дээш жилийн насжилттай тоног төхөөрөмжүүдийг эргэлтэнд оруулаагүй байна.	1	62,800.0			1	62,800.0						
	Зээлийн мэдээллийн санд 223 зээлдэгчийн зээлийн гэрээнд заасан зориулалтыг буруу болон зөрүүтэй бүртгэсэн байна.	1	-			1	-						
Жижиг, дунд үйлдвэрийн газар	Тайлант онд үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Ланд-200 /12-77 УНА/ маркын автотээврийн хэрэгсэлийг даатгалд хамруулж, даатгалын төлбөрт 1,408.9 мянган төгрөгийн зардал гарсан боловч байгалийн үзэгдлийн улмаас гэмтсэн машины засварын зардалд 5.1 сая төгрөгийг даатгалын компаниас нэхэмжлэлгүй төсвөөс санхүүжүүлж, үр ашиггүй зардал гаргасан байна.	1	5,076.3			1	5,076.3						
	Нэр бүхий 36 ажилтанд илүү цагаар ажилласан цагийн бүртгэлгүй байхад 1052 цаг илүү ажилласнаар тооцож	1	23,200.0			1	23,200.0						

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23.2 сая төгрөг олгосон байна.												
Гадаад томилолтын зардлыг олгохдоо хот доторх унааны зардлыг 1.6 сая төгрөгөөр илүү тооцож олгосон.	1	1,597.7	1	1,597.7								
Бельгийн Брюссель, ХБНГУ-ын Фрайбург хотуудад Дэлхийн монголчуудын наадмын үзэсгэсэлэн худалдаа зохион байгуулах зардалд 161.4 сая төгрөгийг шилжүүлсэн боловч гүйцэтгэсэн ажлын тайлан байхгүй байна.	1	161,376.8			1	161,376.8						
ЖДҮГ нь Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэлийн дагуу Дархан-Уул аймагт шилжин ажиллах шийдвэр гарсан боловч зарим албан хаагчид Улаанбаатар хотод ажиллаж, байр ашиглалтын зардалд 19.3 сая төгрөгийг давхардуулан зарцуулж байна.	1	19,335.6					1	19,335.6				
Дүн	12	36,927,091.3	1	1,597.7	8	36,843,358.0	3	82,135.6			-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, Шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээллийн хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12,235.5 сая төгрөг 440 гүйлгээ, 15,369.7 сая төгрөгийн зарлагын 147 гүйлгээг тус тус байршуулаагүй байна.	1	27,605,212.3	1	27,605,212.3	-	-
Жижиг, дунд үйлдвэрийн газар	Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийн хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 57.0 сая төгрөгийн 25 гүйлгээ, 244.4 сая төгрөгийн зарлагын 24 гүйлгээг тус тус байршуулаагүй байна.	1	301,410.8	1	301,410.8	-	-
Дүн		2	27,906,623.1	2	27,906,623.1		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1047/СОМ/411

Улаанбаатар хот

САГ-2026/6/НА-СТА-3ГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангаас тайлант оны жилийн эцсийн байдлаар 324 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд 47,820,548,954.00 /дөчин долоон тэрбум найман зуун хорин сая таван зуун дөчин найман мянга есөн зуун тавин дөрвөн/ төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Үүнээс 26 зээлдэгчийн 4,118,300,000.00 /дөрвөн тэрбум нэг зуун арван найман мянга гурван зуун мянган/ төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 4 зээлдэгчийн 783,200,000.00 /долоон зуун наян гурван сая хоёр зуун мянган/ төгрөгийн зээл хэвийн бус төлөвтэй бөгөөд тайлант онд олгосон нийт зээлийн 10.2 хувь нь сангийн чанаргүй зээлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зориулалттай байна", Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 15 дугаар зүйлийн 15.1-д "Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрч, хэвийн бус зээлийн үлдэгдэл нэмэгдэж, чанаргүй зээлийн эрсдэл нэмэгдэж байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газар¹ т ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга (Я.Эрдэнэсайхан), Ерөнхий нягтлан бодогч (З.Лхагвадорж) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Г.САМПИЛМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316.SAG-71.Docx

1526191283



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1048/COM1411

Улаанбаатар хот

САГ - 2026/6 /НА - СТА - ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12,235,468,167.04/арван хоёр тэрбум хоёр зуун гучин таван сая дөрвөн зуун жаран найман мянга нэг зуун жаран долоон төгрөг дөрвөн мөнгө/ төгрөг 440 гүйлгээ, 15,369,744,154.00 /арван таван тэрбум гурван зуун жаран есөн сая долоон зуун дөчин дөрвөн мянга нэг зуун тавин дөрвөн/ төгрөгийн зарлагын 147 гүйлгээг тус тус байршуулаагүй байна. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"; 4.2.1.1-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулаагүй, өмнөх оны аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга (Я.Эрдэнэсайхан), Ерөнхий нягтлан бодогч (З.Лхагвадорж) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Г.САМПИЛМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1049/С011411

Улаанбаатар хот

САГ-2026/6/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол банкны зээлийн мэдээллийн санд 1300 зээлдэгчийн 193,597,226,807.64 /нэг зуун ерэн гурван тэрбум таван зуун ерин долоон сая хоёр зуун хорин зургаан мянга найман зуун долоон төгрөг жаран дөрвөн мөнгө/ төгрөгийн бодит зээлийн үлдэгдэл бүртгэлтэй байгаагаас гэрээний хугацаа дууссан 21 зээлдэгчийн 1,312,690,606.33 /нэг тэрбум гурван зуун арван хоёр сая зургаан зуун ерин мянга зургаан зуун зургаан төгрөг гучин гурван мөнгө/-ийн зээлийн ангиллыг зөрүүтэй нийлүүлсэн байна. Үүнд: 6 зээлдэгчийн 669,151,986.58 /зургаан зуун жаран есөн сая нэг зуун тавин нэгэн мянга есөн зуун наян зургаан төгрөг тавин найман мөнгө/-ийн зээл хугацаа хэтэрсэн ангилалд, 6 зээлдэгчийн 253,103,303.33 /хоёр зуун тавин гурван сая нэг зуун гурван мянга гурван зуун гурван төгрөг гучин гурван мөнгө/-ийн зээл хэвийн ангилалд, 4 зээлдэгчийн 67,425,784.47 /жаран долоон сая дөрвөн зуун хорин таван мянга долоон зуун наян дөрвөн төгрөг дөчин долоон мөнгө/-ийн зээл хэвийн бус ангилалд, 5 зээлдэгчийн 323,009,531.95 /гурван зуун хорин гурван сая есөн мянга таван зуун гучин нэгэн төгрөг ерин таван мөнгө/-ийн зээл өргөлзээтэй ангилалд байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Зээлийн мэдээллийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "зээлийн мэдээлэл үнэн зөв, бодитой, тодорхой, бүрэн гүйцэд, ойлгомжтой байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Монгол банкны зээлийн мэдээллийн санд зээлийн ангиллыг зөрүүтэй нийлүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга (Я.Эрдэнэсайхан), Ерөнхий нягтлан бодогч (З.Лхагвадорж) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Г.САМПИЛМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9026109
ATA16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-71.Docx

1526181276



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1050/СДМН/11

Улаанбаатар хот

САГ-2026/6/НА-СТА-ЗГТС

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сан нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан хугацаанаас 30 хоног хоцроож Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаа хоцроож ирүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга (Я.Эрдэнэсайхан), Ерөнхий нягтлан бодогч (З.Лхагвадорж) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Г.САМПИЛМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1065/С0111411

Улаанбаатар хот

САГ - 2026/6/НА - СТА - ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шууд зээлийн 202 зээлдэгчийн 30,439,514,342.00 /гучин тэрбум дөрвөн зуун гучин есөн сая таван зуун арван дөрвөн мянга гурван зуун дөчин хоёр/ төгрөгийн авлагын үлдэгдэлийг жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 113 дугаар тогтоолоор баталсан "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох журам"-ын 16 дугаар зүйлийн 16.1.1-т "зээл авсан иргэн, аж ахуй нэгжийн төслийн үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн талаарх тайланг зээлдэгчээс улирал бүр гаргуулан авах"; –гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам", 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Тайлант оны эцэст авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газар¹ т ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга (Я.Эрдэнэсайхан), Ерөнхий нягтлан бодогч (З.Лхагвадорж) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Г.САМПИЛМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1051/СОНМ/М

Улаанбаатар хот

САГ-2026/Б/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Сангийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтөд хураан авсан бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 22,368,437,152.41 /хорин хоёр тэрбум гурван зуун жаран найман сая дөрвөн зуун гучин долоон мянга нэг зуун тавин хоёр төгрөг дөчин нэгэн мөнгө/-ийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгүүдийг эргэлтэд оруулахаар дуудлага худалдаа зохион байгуулсан боловч сонирхогч этгээд оролцоогүй байна. Тус хөрөнгүүдийн ашиглалт, хадгалалт, хамгаалалттай холбоотой зардал нэмэгдэж, хөрөнгийн чанар байдал алдагдан, сангийн түргэн хөрвөх чадварт сөргөөр нөлөөлж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Жижиг, дунд, үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний хууль тогтоомж, төрийн бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах", ЗГ-ын 113 дугаар тогтоолоор баталсан "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 2 дугаар сарын 2.1-т "Зээлийн эх үүсвэр нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан эх үүсвэрээс бүрдэнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"; гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, эргэн төлөлтөд хураан авсан хөрөнгийг эргэлтэд оруулаагүй, урсгал зардал гаргаж байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга (Я.Эрдэнэсайхан), Ерөнхий нягтлан бодогч (З.Лхагвадорж) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Г.САМПИЛМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316\SAG-71.Docx

1526191780



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 202/CO111411

Улаанбаатар хот

САГ-2026/87/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаад томилолтын зардлыг олгоходоо хот доторх унааны зардлыг 1,597,743.00 /нэг сая таван зуун ерэн долоон мянга долоон зуун дөчин гурван/ төгрөгөөр илүү тооцож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Сангийн сайдын 2011 оны 188 дугаар "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" Хоёр. Гадаад томилолтоор явагчдад хот доторх унааны зардлын хэмжээг тухайн хотод байх хугацааг хоногт 10 ам.доллаар тооцож олгосугай" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон 1,597,743.00 /нэг сая таван зуун ерэн долоон мянга долоон зуун дөчин гурван/ төгрөгийг хавсралтад дурдсан нэр бүхий 6 иргэнээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар¹т ирүүлэхийг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга (Я.Эрдэнэсайхан), Ерөнхий нягтлан бодогч (З.Лхагвадорж) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

Г.САМПИЛМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1046/CO111411

Улаанбаатар хот

САГ-2026/87/НА-СТА-ТЦУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бельгийн Брюссель, Холбооны Бүгд Герман улсын Фрайбург хотуудад Дэлхийн Монголчуудын наадмын үзэсгэсэлэн худалдаа зохион байгуулах зардалд 161,376,803.00 /нэг зуун жаран нэгэн сая гурван зуун далан зургаан мянга найман зуун гурван/ төгрөгийг шилжүүлсэн боловч гүйцэтгэсэн ажлын тайлан байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй; гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй, гүйцэтгэсэн ажлын тайланг хавсаргаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга (Я.Эрдэнэсайхан), Ерөнхий нягтлан бодогч (З.Лхагвадорж) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Г.САМПИЛМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1044/С0111411

Улаанбаатар хот

САГ-2026/87/КА -СТА -ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Тоёота Ланд Круйзер-200 маркын 12-77 УНА улсын дугаар бүхий автотээврийн хэрэгсэлийг даатгалд хамруулж, даатгалын төлбөрт 1,408,900.00 /нэг сая дөрвөн зуун найман мянга есөн зуун/ төгрөгийн зардал гарсан боловч байгалийн гамшигт үзэгдлийн улмаас гэмтсэн машины засварын зардалд 5,076,300.00 /таван сая даланзургаан мянга гурван зуун/ төгрөгийг даатгалын компаниас нэхэмжлэлгүй төсвөөс санхүүжүүлж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн"; гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Даатгалын байгууллагаас төлбөрийг нөхөн гаргуулах арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга (Я.Эрдэнэсайхан), Ерөнхий нягтлан бодогч (З.Лхагвадорж) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
АУДИТЫН МЕНЕЖЕР,
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Г.САМПИЛМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1043/С0111411

Улаанбаатар хот

САГ -2026/87/НА-СТА -ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Илүү цагаар ажилласан ажилтаны бүртгэлийн хуудсыг баталгаажуулаагүй нэр бүхий 36 ажилтанд 1052 цаг илүү ажилласнаар тооцож 23,200,000.00 /хорин гурван сая хоёр зуун мянган/ төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Илүү цагаар ажилласан ажилтны бүртгэлийн хуудсыг баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга (Я.Эрдэнэсайхан), Ерөнхий нягтлан бодогч (З.Лхагвадорж) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
АУДИТЫН МЕНЕЖЕР,
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Г.САМПИЛМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1045/С0111411

Улаанбаатар хот

САГ-2026/87/НА -СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 57,034,100.00 /тавин долоон сая гучин дөрвөн мянга нэг зуун/ төгрөгийн 25 гүйлгээ, 244,376,736.00 /хоёр зуун дөчин дөрвөн сая гурван зуун далан зургаан мянга долоон зуун гучин зургаан/ төгрөгийн зарлагын 24 гүйлгээг тус тус байршуулаагүй байна. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулдаггүй, өмнөх оны аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга (Я.Эрдэнэсайхан), Ерөнхий нягтлан бодогч (З.Лхагвадорж) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Г.САМПИЛМАА